**ӨМНӨГОВЬ АЙМАГ**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 29 өдөр Дугаар А/14 Даланзадгад сум

Эрүүл мэндийн эрдэм шинжилгээ судалгаа, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах дүрэм батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/33 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/195 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эрдэм шинжилгээ судалгаа, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөвлөлийн ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дүрмийн дагуу үйл ажиллагааг явуулах, эмч мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх, тэдний нэвтрүүлсэн шинэ технологи, тэргүүн туршлагыг баталгаажуулах, сурталчлах, нэвтрүүлэх ажлыг чанартай зохион байгуулахыг зөвлөл, түүний гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбоотой Эрүүл мэндийн газрын 2018 оны А/12 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНШАГАЙ

My computer 2023 tushaal